



**ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН  
АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ  
СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТАД ХИЙСЭН ХЭРЭГЖИЛТИЙН  
ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ**

**2024**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**IX сар**



**Судалгааг захиалагч:**

Хууль зүй, дотоод хэргийн яам

**Судалгааг хянасан:**

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,  
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

**Судалгааг удирдсан:**

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

**Судалгааг гүйцэтгэсэн:**

Р.Хатансайхан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)

Б.Баярмаа

Эрдэм шинжилгээний ажилтан

О.Түвшинсанаа

Эрдэм шинжилгээний ажилтан



## АГУУЛГА

|                                                                                                                                                 |           |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>УДИРТГАЛ .....</b>                                                                                                                           | <b>4</b>  |
| <b>НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....</b>                                                                                                                | <b>5</b>  |
| 1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь .....                                                                                               | 5         |
| 1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох .....                                                                                                          | 5         |
| 1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох .....                                                                                                   | 8         |
| 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох .....                                                                                                          | 8         |
| 1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох .....                                                                                                        | 9         |
| 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох .....                                                                                                      | 16        |
| <b>ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....</b>                                                                                                            | <b>17</b> |
| <b>ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ .....</b>                                                                                                               | <b>18</b> |
| 3.1.Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн байдал ..... | 18        |
| 3.1.1. Зорилгод хүрсэн түвшин .....                                                                                                             | 18        |
| 3.1.2. Практикт нийцэж байгаа байдал .....                                                                                                      | 22        |
| 3.2.Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг үнэлсэн байдал. ....                                                        | 25        |
| 3.2.1. Зорилгод хүрсэн түвшин .....                                                                                                             | 25        |
| 3.2.2. Практикт нийцэж байгаа байдал .....                                                                                                      | 30        |
| <b>ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....</b>                                                                                                            | <b>34</b> |
| <b>НОМ ЗҮЙ.....</b>                                                                                                                             | <b>37</b> |

## УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.2-д заасан “Авлигагүй засаглал”-ыг бий болгохын тулд гол дөрвөн чиглэлийг баримтлах ёстой.Үүнд:

- 4.2.1.“Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа”-ны хүрээнд 16 хөтөлбөр,
- 4.2.2.“Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал”-ын хүрээнд 5 хөтөлбөр,
- 4.2.3.“Төрийн албаны шинэчлэл”-ын хүрээнд 13 хөтөлбөр,
- 4.2.4.“Орон нутгийн засаглалын бие даасан байдал”-ын хүрээнд 5 хөтөлбөр нийт 39 хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг юм.<sup>1</sup>

Энэхүү “Авлигагүй засаглал”-д хамаарах 39 хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчны өнөөгийн нөхцөлд үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай.

Мөн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэж хуульчилжээ. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйл, 10 дугаар зүйл, 16 дугаар зүйл, 19 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйл, 22 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, 35 дугаар зүйл, 36 дугаар зүйл, 37 дугаар зүйлийн хэрэгжилтийг үнэлсэн судалгаа хийгдээгүй байна.

Иймд, хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох үүднээс Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг хийх шаардлагатай гэж үзлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж, гүйцэтгэлээ.

---

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368141311> , Сүүлд үзсэн огноо: 2024.09.18.



## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэв.

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

### 1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох нь

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль нь 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсанаас хойш өдийг хүртэл 18 удаа /2012, 2013, 2014, 2015, 2016, 2017, 2020, 2021, 2022, 2023, 2024/ нэмэлт өөрчлөлт орсон. <sup>2</sup>

Харин Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 2020 оны 05 сарын 01-ний өдөр батлагдсанаас хойш өдийг хүртэл 5 удаа нэмэлт өөрчлөлт /2021, 2023/ нэмэлт өөрчлөлт оржээ. <sup>3</sup>

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.2-д “Авлигагүй засаглал”-ийн тусгасан. Энэхүү “Авлигагүй засаглал”-ийг бий болгох 39 хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйл, 10 дугаар зүйл, 16 дугаар зүйл, 19 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйл, 22 дүгээр зүйл, 23 дугаар зүйл, 35 дугаар зүйл, 36 дугаар зүйл, 37 дугаар зүйлийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлэх, цаашид бэхжүүлэх шаардлагыг тодорхойлох нь зүйтэй.

### 1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох


Судалгааны үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаагаар нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлдог.

Үнэлгээний хүрээг үнэлгээ хийх болсон шалтгаантай харилцан уялдаа, хамааралтайгаар тогтооно. Ингэхдээ үнэлгээний хүрээгээр тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий

---

<sup>2</sup> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012 он.

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хууль, УБ, 2020 он.



харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг сонгоно. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.

Энэхүү судалгаагаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулиар зохицуулсан үндсэн харилцаа, зохицуулалтуудыг аль болох агуулгын хувьд бүхэлд нь үнэлэхийг хичээж үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл заалтуудаар тогтоов. Үүнд:

1) Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2<sup>4</sup>, 8.3<sup>5</sup>, 8.6<sup>6</sup> дахь хэсэг;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10<sup>1</sup>.2<sup>7</sup>, 10<sup>1</sup>.5<sup>8</sup> дахь хэсэг;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг<sup>9</sup>;

---

<sup>4</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 8 дугаар зүйлийн 8.2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

<sup>5</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 8 дугаар зүйлийн 8.3. Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээлж болно.

<sup>6</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 8 дүгээр зүйлийн 8.6. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

<sup>7</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 10<sup>1</sup> дугаар зүйлийн 10<sup>1</sup>.2. Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлэх үүрэгтэй.

<sup>8</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 10<sup>1</sup> дугаар зүйлийн 10<sup>1</sup>.5. Албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөхөд энэ хуулийн 10<sup>1</sup>.1 дэх хэсэг хамаарахгүй. Хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

<sup>9</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 16 дугаар зүйлийн 16.4. Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг<sup>10</sup>;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг<sup>11</sup>;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4<sup>12</sup> дэх хэсэг зэрэг болно.

## 2) Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга

- Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>13</sup> дахь хэсэг;
- Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1<sup>14</sup> дэх хэсэг;
- Төрийн аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1<sup>15</sup> дэх хэсэг;
- Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1<sup>16</sup> дэх хэсэг;
- Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1<sup>17</sup> дэх хэсэг
- Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2<sup>18</sup> дахь хэсэг зэрэг болно.

<sup>10</sup> НАНБХАСЗАСЗУСТХ, 19 дүгээр зүйлийн 19.1. Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.

<sup>11</sup> Төрийн аудитын тухай хууль, 23 дугаар зүйлийн 23.3. Албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

<sup>12</sup> 26.4. Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

<sup>13</sup> Төрийн аудитын тухай хууль, 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

<sup>14</sup> Төрийн аудитын тухай хууль, 21 дугаар зүйлийн 21.1. Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.

<sup>15</sup> Төрийн аудитын тухай хууль, 22 дугаар зүйлийн 22.1. Төрийн аудитын байгууллага албан шаардлага, төлбөрийн актыг шалгагдагч этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй аудитад хамрагдагчид Захиргааны ерөнхий хуульд заасан журмаар мэдэгдэнэ.

<sup>16</sup> Төрийн аудитын тухай хууль, 23 дугаар зүйлийн 23.1. Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

<sup>17</sup> Төрийн аудитын тухай хууль, 35 дугаар зүйлийн 35.1. Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ.

<sup>18</sup> Төрийн аудитын тухай хууль, 37 дугаар зүйлийн 37.2. Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

### 1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал.

#### I. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь зохимжтой байдаг. Энэхүү онцлог нь тус судалгааны зорилгод нийцэж буй юм. Мөн зорилгод хүрсэн түвшин нь хэдийгээр харьцангуй хийсвэр ч тус шалгуур шалгуур үзүүлэлт нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ерөнхий дүн шинжилгээ хийхэд чухал үүрэгтэй байдаг. Иймд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үнэлэхэд тохиромжтой гэж үзлээ.

Энэхүү шалгуур үзүүлэлтээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалт нь хэрэгжиж эхэлснээс хойших хугацаандаа анх батлагдах үед төлөвлөсөн зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно.

#### II. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон.

### 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамааран, аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгодог. Харьцуулах доор дурдсан хэлбэрүүд байна. Үүнд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/ тохиолдол судлах.

Дээрхээс “хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш”, “хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш”, “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг энэхүү судалгаанд тохиромжтой гэж үзэж сонгов.

“Хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш” харьцуулах хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалт хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж, хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

“Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш” харьцуулах хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар судалж тогтооход чиглэгдэнэ.

“Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

### 1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэх асуултын хүрээнд гүйцэтгэлээ.

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт.

| Үнэлгээний хүрээ                                                                                                                                                                                                       | Тогтоосон шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | Харьцуулах хэлбэр                                                                                                                                                                                                                                                                                        | Шалгуур үзүүлэлт                                                                       |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                                        | Зорилгод хүрсэн түвшин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                        |
| <b>Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах үүрэг.</b><br><br>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6/ | Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй” гэж хуульчилсан. Мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-д ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхээр хуульчилсан. Эдгээр зүйл заалт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг | “Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6-д заасан ашиг сонирхлыг мэдэгдэх тайлбарлах үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална. | Ашиг сонирхлыг зөрчлийг мэдэгдэх тайлбарлах үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх. |

|                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                            |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                                                                                                                                        | сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                            |
| <b>Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт</b><br><br>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 <sup>1.2</sup> , 10 <sup>1.5</sup> / | Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10 <sup>1.2</sup> , 10 <sup>1.5</sup> -д заасан мэдэгдэх үүрэг нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө. | “Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 <sup>1.2</sup> , 10 <sup>1.5</sup> -р заасан ашиг сонирхлыг мэдэгдэх тайлбарлах үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална. | Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолтыг мэдэгдэх үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх. |

|                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                                                                                             |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Бэлэг авахтай холбогдсон мэдэгдэх үүрэг</b></p> <p>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4/</p>         | <p>Тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д заасан “бэлэг авахтай холбогдсон мэдэгдэх үүрэг” нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p>         | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д заасан зохицуулсан бэлэг авахтай холбогдсон хязгаарлалтын мэдэгдэх үүрэг мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p> | <p>Бэлэг авахтай холбогдсон мэдэгдэх үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p>         |
| <p><b>Давхар ажил эрхлэхтэй холбогдсон мэдэгдэх үүрэг</b></p> <p>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1/</p> | <p>Тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан “давхар ажил эрхлэхтэй холбогдсон мэдэгдэх үүрэг” нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p> | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 д заасан давхар ажил эрхлэхтэй холбогдсон мэдэгдэх үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p>                | <p>Давхар ажил эрхлэхтэй холбогдсон мэдэгдэх үүрэг нь хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p> |
| <p><b>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах</b></p> <p>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг</p>                                                                                                         | <p>Тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах үүрэг” нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг</p>                                                                                                                    | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар</p>                                                                                                                                               | <p>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах эрх зүйн зохицуулалт нь хуулийн зорилгод</p>       |

|                                                                                               |                                                                                                         |                                                                                                                     |                  |
|-----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|
| зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3/ | зохицуулах, төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө. | зүйлийн 23.3-д заасан хувийн ашиг сонирхлын мэдэгдэх үүрэг нь мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална. | нийцэж буй эсэх. |
|-----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|

Хүснэгт 2. Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт.

| Үнэлгээний хүрээ                                                                                                                                                                                              | Тогтоосон шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | Харьцуулах хэлбэр                                                                                                                                                                                                                                               | Шалгуур үзүүлэлт                                                                                 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                                                                               | Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                  |
| <b>Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан шалгах</b><br><br>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4/ | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-д “Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно” гэж хуульчилсан.<br><br>Энэхүү зүйл заалтыг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална | “Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-р зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний практик хэрэгжилтийг судална. | Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан шалгах эрх зүйн зохицуулалт практик хэрэгжиж байгаа эсэх. |

Хүснэгт 3. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт /Төрийн аудитын тухай хууль/

| Үнэлгээний хүрээ                                    | Тогтоосон шалгуур үзүүлэлт                                                                                                                                                            | Харьцуулах хэлбэр                                                                                                                             | Шалгуур үзүүлэлт                                                                |
|-----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|
|                                                     | Зорилгод хүрсэн түвшин                                                                                                                                                                |                                                                                                                                               |                                                                                 |
| <b>Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох.</b> | Тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 –д заасан “албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” эрх зүй зохицуулалт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, | “Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан албан шаардлага | Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох эрх зүйн зохицуулалт төрийн аудитын |

|                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                      |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 21 дүгээр зүйлийн 21.1/</p>                                                                  | <p>ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                            | <p>өгөх, төлбөрийн акт тогтоох эрх зүйн зохицуулалт мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p>                                                                                                                                              | <p>тухай хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p>                                                                                       |
| <p><b>Албан шаардлага, төлбөрийн актыг мэдэгдэх</b></p> <p>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 22 дугаар зүйлийн 22.1/</p>          | <p>Тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан “Төрийн аудитын байгууллага албан шаардлага, төлбөрийн актыг шалгагдагч этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй аудитад хамрагдагчид Захиргааны ерөнхий хуульд заасан журмаар мэдэгдэх” заалт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p> | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 22 дугаар зүйлийн 22.1-д албан шаардлага, төлбөрийн актыг мэдэгдэх эрх зүйн хэм хэмжээ мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p>          | <p>Албан шаардлага, төлбөрийн актыг мэдэгдэх эрх зүйн хэм хэмжээ төрийн аудитын тухай хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p>          |
| <p><b>Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах</b></p> <p>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлийн 23.1/</p> | <p>Тус хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан “Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэх” заалт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилгод нийцэж байгаа эсэхэд үнэлэлт өгнө.</p>                                                       | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлийн 23.1-д Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах эрх зүйн хэм хэмжээ мөн хуулийн зорилготой нийцэж байгаа эсэхийг судална.</p> | <p>Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах эрх зүйн хэм хэмжээ төрийн аудитын тухай хуулийн зорилгод нийцэж буй эсэх.</p> |

Хүснэгт 4. Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт /Төрийн аудитын тухай хууль/

| Үнэлгээний хүрээ                                                                                                                                  | Тогтоосон шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Харьцуулах хэлбэр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                         |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                   | Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                          |
| <b>Төрийн аудитын тайлан</b><br><br>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлийн 20.5/                                   | Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална | “Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар 20.5-р зүйлээр зохицуулж буй төрийн аудитаас гаргасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төрийн аудитын байгууллагад ирүүлэх зохицуулалтын практик хэрэгжилтийг судална.                                                                                                   | Төрийн аудитаас гаргасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төрийн аудитын байгууллагад ирүүлэх зохицуулалт практик хэрэгжиж байгаа эсэх.                                                                                                  |
| <b>Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хуралтай харилцах</b><br><br>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33 дугаар зүйлийн 33.5/ | Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33 дугаар зүйлийн 33.5-д “Монгол Улсын Ерөнхий аудитор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлнэ” гэж хуульчилсан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална                        | “Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33 дугаар зүйлийн 33.5-р зохицуулж буй Монгол Улсын Ерөнхий аудитор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлэх зохицуулалтын практик хэрэгжилтийг судална. | Монгол Улсын Ерөнхий аудитор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлэх зохицуулалт практик хэрэгжиж байгаа эсэх |

|                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p><b>Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах</b></p> <p>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 35 дугаар зүйлийн 35.1/</p> | <p>Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 35 дугаар зүйлийн 35.1-д “аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ” гэж хуульчилсан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална</p> | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 35 дугаар зүйлийн 35.1-р зохицуулж буй аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэх зохицуулалтын практик хэрэгжилтийг судална.</p> | <p>Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэх зохицуулалт практик хэрэгжиж байгаа эсэх</p> |
| <p><b>Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах</b></p> <p>/Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 37</p>               | <p>Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 37 дугаар зүйлийн 37.2-д “Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж,</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | <p>“Тохиолдол судлах” харьцуулалтын хэлбэрээр Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 37 дугаар зүйлийн 37.2-р зохицуулж буй “Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц,</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             | <p>Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас</p>                                                                                                                                                                                                                                                                                                                        |

|                         |                                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                          |
|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| дугаар зүйлийн<br>37.2/ | өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ” гэж хуульчилсан. Энэхүү заалтыг хэрэгжүүлэхэд ойлгомжтой бичигдэж чадсан эсэх, тус зүйлийг хэрэгжүүлснээр практикт ямар нэг сөрөг үр дагавар гарч байгаа эсэх буюу хэрэгжүүлэхэд асуудал үүсэж буй, үүсэж байсан тухай судлаачид хэрхэн үзэж байгаа талаар судална. | хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх” зохицуулалтын практик хэрэгжилтийг судална. | бусад аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэх |
|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

#### 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас судалгааг гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд тухайн чиглэлээр бичигдсэн холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.



## **ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Төрийн аудитын ажиллагааг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

Тус судалгаанд ашигласан эх сурвалжийг судалгааны эх сурвалж хэсгээс харна уу.

## ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү үнэлэх үе шатанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн аудитын тухай хуулийн зарим зүйл заалтуудыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

### 3.1. Нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг үнэлсэн байдал

#### 3.1.1. Зорилгод хүрсэн түвшин

| № | Үнэлгээ хийх хуулийн зүйл заалт                                | Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт |
|---|----------------------------------------------------------------|-------------------------------|
| 1 | 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг.                               | Зорилгод хүрсэн түвшин        |
| 2 | 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг.                               | Зорилгод хүрсэн түвшин        |
| 3 | 10 <sup>1</sup> дугаар зүйлийн 10 <sup>1</sup> .2 дахь хэсэг.  | Зорилгод хүрсэн түвшин        |
| 4 | 10 <sup>1</sup> дугаар зүйлийн 10 <sup>1</sup> .5. дахь хэсэг. | Зорилгод хүрсэн түвшин        |
| 5 | 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг.                              | Зорилгод хүрсэн түвшин        |
| 6 | 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.                              | Зорилгод хүрсэн түвшин        |

#### 8 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах

8.2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

8.6. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр эсхүл цахим хэлбэрээр тайлбар хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

#### 10<sup>1</sup> дугаар зүйл. Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт

10<sup>1</sup>.2. Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлэх үүрэгтэй.

10<sup>1</sup>.5. Албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөхөд энэ хуулийн 10<sup>1</sup>.1 дэх хэсэг хамаарахгүй. Хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

## **16 дугаар зүйл. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт**

16.4.Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

## **19 дүгээр зүйл. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам**

19.1.Албан тушаалтан нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.

Монгол Улс 2005 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Авлигын эсрэг конвенцод (UNCAC) гарын үсэг зурж, мөн оны 10 дугаар сарын 27-ны өдөр уг конвенцыг соёрхон баталсан. Тус конвенцын 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс бүр нийгмийн оролцоог хөхиүлэн дэмжсэн, хууль дээдлэх ёс, нийтийн хэрэг болон нийтийн эд хөрөнгийг зохистойгоор удирдах, үнэнч шударга, ил тод байх, хариуцан тайлагнах зарчмыг тусгасан авлигын эсрэг үр дүнтэй, уялдаа холбоо бүхий бодлогыг эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050”, мөн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан 2023 онд “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр /2023-2030/-ийг баталсан. Тус хөтөлбөрийн 2.2.2-д “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулаагүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг томилсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.”, 5.2.2-д “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.”, 5.2.3-д “Авлига, ашиг сонирхлын зөрчил болон сахилга, ёс зүйн зөрчилд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтын үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгоно.” гэж заасан.

Манай улс дээрх нэгдэн орсон конвенц болон Монгол Их Хурлаас баталсан бодлого, хөтөлбөрүүдийн хүрээнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих зорилгоор 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль” /цаашид “НАНБХАСЗАСЗУСтХ” гэх/-ийг баталжээ.

НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Энэ хуулийн зорилт нь нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, хянах замаар нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх нөхцөлийг баталгаажуулж төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангахад оршино.” гэж заасан.

Дээрх зорилтын хүрээнд хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6, 10 дугаар зүйлийн 10<sup>1</sup>.2, 16 дугаар зүйлийн 16.4, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан зохицуулалтуудыг үзвэл:

## 1. Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан тушаалд нэр дэвшигч нь:

- Оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан эсэх талаар *‘холбогдох байгууллагад’*,
- Нийтийн албанд орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа эсэх талаар *‘дээд шатны албан тушаалтанд’*,

## 2. Нийтийн албан тушаалтан нь:

- Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн бол *‘эрх бүхий байгууллага, албан тушаалтанд’*,
- Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал бий болсон тохиолдолд энэ талаар *‘эрх бүхий байгууллага, албан тушаалтанд’* бичгээр эсхүл цахимаар мэдэгдэх үүрэгтэй талаар зохицуулсан байна.


Нийтийн албан тушаалтан нь а) ашиг сонирхлын зөрчил үүссэн, б) ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй, с) ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл бий болсон тохиолдолд энэ талаар *‘мэдэгдэх’* үүргийг хуульчилсан нь нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан нөхцөлийг арилгах, авлигаас урьдчилан сэргийлэхийн сацуу албан хаагчдад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, аливаа хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах боломжийг олгодог гэдгээрээ ач холбогдолтой.

Гэтэл мэдэгдэл хүлээн авагчийг хуульчлахдаа *‘холбогдох байгууллагад’*, *‘дээд шатны албан тушаалтанд’*, *‘эрх бүхий байгууллага, албан тушаалтанд’* гэж ерөнхий байдлаар томъёолсон нь учир дутагдалтай байна.

Жишээ нь Канад улсын төрийн албаны ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх, ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий 2006 онд баталсан Ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх тухай хуульд (Conflict of Interest Act)<sup>19</sup> төрийн албан хаагч нь шинээр албан тушаалд томилогдох, эсхүл тухайн албанаас чөлөөлөгдөх, мөн жил бүрийн өөрийн ашиг сонирхлын мэдүүлгийг энэ хууль болон байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцсан алба, эсхүл удирдлагад гаргах үүрэгтэй бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсэж болзошгүй тохиолдолд Ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн асуудал эрхэлсэн комисст (Office of the Conflict of Interest and Ethics Commissioner)<sup>20</sup> мэдэгдэж байхаар зохицуулжээ.

<sup>19</sup> Conflict of Interest Act, 2006, Холбоос: <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-36.65/fulltext.html>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.18.

<sup>20</sup> “Office of the Conflict of Interest and Ethics Commissioner” буюу “Ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн асуудал эрхэлсэн комисс” гэдэг нь төрийн албан хаагчдын ашиг сонирхлын мэдүүлгийг хүлээн авах, хянах, үнэлэх, зөвлөмж өгөх чиг үүрэгтэй байгууллага юм.



Мөн Их Британи улсын 1997 оны Төрийн албаны тухай хууль (The Civil Service Act)<sup>21</sup>, 2009 оны Парламентын Стандартын тухай хууль (Parliamentary Standards Act)<sup>22</sup>, 2005 оны Парламентын гишүүдийн ёс зүйн код (Code of Conduct for Members of Parliament)<sup>23</sup>, 2011 оны Орон нутгийн удирдлагын тухай хуульд (Localism Act)<sup>24</sup> зааснаар:

1. Парламентын гишүүн, Засгийн газрын гишүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтан нь Парламентын Стандартын Зохицуулах бие даасан байгууллагад (Independent Parliamentary Standards Authority, IPSA)<sup>25</sup>,
2. Орон нутгийн засаг захиргааны алба хаагчид нь орон нутгийн зөвлөл (Local Council), болон орон нутгийн албанд (Local Authority),
3. Бусад төрийн албан хаагч нь байгууллагын дотоод журамд заасны дагуу хариуцсан алба, эсхүл удирдлагад хандан ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсэж болзошгүй талаар мэдэгдэхээр зохицуулсан байна.

Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх үүргийг хуульчлахдаа мэдэгдэл хүлээн авагчийг тодорхой зааж өгөөгүй нь НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилтыг зохих түвшинд хүртэл хэрэгжүүлэх боломжгүй нөхцөлийг бүрдүүлэх юм. Ялангуяа НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6 дахь хэсэгт *‘эрх бүхий байгууллага, албан тушаалтанд’* гэж заасан нь яг хэнд хандах нь ойлгомжгүй, төөрөгдөл үүсгэсэн зохицуулалт байна. Иймд ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх үүргийг хуульчлахдаа мэдэгдэл хүлээн авагчийг тодорхойгүй, хэт ерөнхий байдлаар томъёолох бус илүү нарийвчлан дэлгэрүүлэх шаардлагатай. Ингэснээр нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөн төрийн албан хаагчдад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, аливаа хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах боломж нөхцөл бүрдэх юм.

---

<sup>21</sup> The Civil Service Act, 1997.

<sup>22</sup> Parliamentary Standards Act, 2009, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2009/13/contents>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.18.

<sup>23</sup> Code of Conduct for Members of Parliament, 2005, Холбоос: <https://publications.parliament.uk/pa/cm5803/cmcode/1083/report.html>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.18.

<sup>24</sup> Localism Act, 2011, Холбоос: <https://www.legislation.gov.uk/ukpga/2011/20/contents>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.18.


<sup>25</sup> “Independent Parliamentary Standards Authority” гэдэг нь Их Британи улсын төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө, орлого болон аливаа ашиг сонирхол, хамаарлыг хянах чиг үүрэг бүхий байгууллага юм.

### 3.1.2. Практикт нийцэж байгаа байдал

#### 26 дугаар зүйл. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянах

26.4. Авлигатай тэмцэх газар өргөдөл, мэдээллийн мөрөөр, эсхүл төлөвлөгөөт хяналтаар шалгалт явуулж болно.

НАНБХАСЗАСЗУСтХ-д нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх дараах механизмыг бүрдүүлсэн.<sup>26</sup> Үүнд:



Хэрэгжилтийг хянах механизмын хүрээнд хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх хэсэгт Авлигатай тэмцэх газар нь хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, төлөвлөгөөт хяналт, шалгалт болон иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу төрийн албан хаагчдын ашиг сонирхлын мэдүүлгийг хянах тухай зохицуулалтыг тусгасан байна.

Ийнхүү хуульчилсны дагуу хуулийн хэрэгжилтийг хянах механизм практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар судлахад:

1. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 226.496<sup>27</sup> төрийн албан хаагч байснаас 47.182 албан хаагч нь хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан бол 2024 оны эхний хагас жилд энэ тоо 50.258<sup>28</sup> буюу 6.52 хувиар өсжээ. Эдгээр мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалтын алба хүлээн авах бөгөөд тус албанд одоогоор 20 гаруй албан хаагч ажиллаж байна.<sup>29</sup> Үүнээс үзвэл тус албаны нэг ажилтан жилд дунджаар 2500 гаруй мэдүүлэг, зөрчлийг хянан шалгахгаар байгаа нь улсын хэмжээнд төрийн албан хаагчдын ашиг сонирхлын мэдүүлгийг хянах нэгж, албан хаагчийн тоо хангалтгүй байгааг илтгэх бөгөөд ашиг сонирхлын мэдүүлгийг хянах чиг үүрэгтэй нэгж, албан хаагчдын тоог нэмэх шаардлагатай болохыг харуулж байна.

2. Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлыг холбогдох байгууллагад мэдээлэх нь хяналт тавих механизмын хэрэгжилтийг сайжруулахад чухал ач холбогдолтой. Ийнхүү мэдээлэх байдал манай улсад ямар байгаа талаар судлахад сүүлийн 5 жилийн хугацаанд

<sup>26</sup> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 100 асуулт, хариулт, Авлигатай тэмцэх газар, (УБ, 2012), 4 дэх тал.

<sup>27</sup> Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн 2023 оны тайлан, Төрийн албаны зөвлөл, (УБ, 2024), 5 дахь тал.

<sup>28</sup> Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2024), Холбоос: <https://iaac.mn/post/157379>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

<sup>29</sup> 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр, Авлигатай тэмцэх газрын холбогдох ажилтантай хийсэн ярилцлагын үеэр тодруулахад байгууллагын нууцтай холбоотойгоор тодорхой тоо хэлэх боломжгүй гэв.

хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийн тоо 8.5 хувиар, ашиг сонирхлын зөрчил, авлигатай холбоотой гомдол, мэдээллийн тоо 11.70 хувиар тус тус өсжээ.

График 1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийн тоо (2019-2023)





График 2. Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийн тоо (2019-2023)



Эдгээр өргөдөл, гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн Хяналт шалгалтын албан хаагчид болон нэмэлтээр Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн албан хаагч нар хүлээн авч байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлсэн, түүнчлэн хянан шалгах ажиллагаанд субъектив хандлагаар нөлөөлөх эрсдэлийг бий болгох сул талтай юм.<sup>30</sup>

<sup>30</sup> Авлигатай тэмцэх газар нар, “Авлигыг мэдээлэх системийн хэрэгцээ шаардлагыг үнэлэх нь” судалгааны тайлан, (УБ, 2024), 17 дахь тал.

### Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх талаар хуульд заасан зохицуулалтыг үзвэл:

НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэхээр заасан боловч 'бусад этгээд' гэдэгт хэнийг ойлгох талаар нэр томъёоны тодорхойлолт байхгүй байна. Үүнээс шалтгаалан уг зохицуулалт хэнд үйлчлэх нь тодорхойгүй байхын зэрэгцээ мэдээлээгүй тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан нь хариуцлагаас мултрах, мөн зүйл заалтыг өөрт ашигтайгаар буруу тайлбарлаж хэрэглэх нөхцөлийг бүрдүүлжээ. Мөн уг зохицуулалтаас өөр ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх талаар хуулийн зохицуулалт байхгүй байна.

Гэтэл дээрх графикт иргэдийн ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх байдал өссөн нь энэ төрлийн харилцааг хуульчлан зохицуулах хэрэгцээ шаардлага үүссэн болохыг харуулж байна. Тодруулбал, 2023 оны "Авлигыг мэдээлэх системийн хэрэгцээ шаардлагыг үнэлэх нь" сэдэвт судалгааны ажлын хүрээнд иргэд, олон нийтийн зүгээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээлэл гарган шийдвэрлүүлж буй тодорхой үе шатанд тулгарч буй асуудлыг тодорхойлох зорилгоор иргэдээс асуумж судалгаа авахад дараах үр дүн гарчээ. Үүнд:<sup>31</sup>



Тус графикаас үзвэл, судалгаанд оролцогчдын дийлэнх нь авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотойгоор өргөдөл, гомдол гаргах гэхэд нэр, хаяг, регистрийн дугаар зэргийг шаарддаг нь өөрийн хувийн нууцлалыг алдах вий гэх болгоомжилдог, мөн энэ талаарх асуудлаар хандах нь эрсдэлтэй гэж үзжээ. Иймээс хуулийн хэрэгжилтийг хянах механизмыг сайжруулахын тулд Авлигатай тэмцэх газрын хянах чиг үүрэгтэй нэгж, албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, мөн мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог НАНБХАСЗАСЗУСтХ-д бий болгох шаардлагатай байна.

<sup>31</sup> Авлигатай тэмцэх газар нар, "Авлигыг мэдээлэх системийн хэрэгцээ шаардлагыг үнэлэх нь" судалгааны тайлан, (УБ, 2024), 18 дахь тал.

### 3.2.Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг үнэлсэн байдал.

#### 3.2.1. Зорилгод хүрсэн түвшин

##### 21 дүгээр зүйл.Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох

21.1.Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.

Манай Улсын хувьд 2003 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр “Төрийн аудитын тухай” анхдагч хуулийг баталсан.<sup>32</sup> Энэхүү хуулийн зорилт нь “төрийн аудитын тогтолцоо, төрийн аудитыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, төрийн аудитыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж” байв.<sup>33</sup>

2003 оны “Төрийн аудитын тухай” хуульд батлагдсанаас хойш 17 жилийн хугацаанд 10 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Эдгээр нэмэлт, өөрчлөлтийг оруулах явцад анх батлагдсан хуулийн 58 хувь нь өөрчлөгдөж, хуулийн бүтэц, нэр томьёо, хэсэг, заалт хоорондын уялдаа алдагдсан. Тухайлбал, 2006 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн, 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн, 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиудаар оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь Төрийн аудитын тухай хуулийн нийт зохицуулалтын 50-аас дээш хувьд оруулсан нэмэлт, өөрчлөлт оруулсан. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1<sup>34</sup> дэх заалтыг үндэслэн “Төрийн аудитын тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг 6 бүлэг, 43 заалттайгаар 2020 онд баталсан.<sup>35</sup>

Нөгөө талаас 2018, 2019 онд Төрийн аудитын байгууллагаас гаргасан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэж үзвэл 77.9 хувьтай буюу төлбөрийн актын хэрэгжилтийн хувь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй ажиглагджээ.<sup>36</sup> Тодруулбал, төрийн аудитын газраас 2018 онд Үндэсний аудитын газраас 1955 төлбөрийн акт гаргасан бөгөөд үүний 1476 нь биелсэн. 2019 онд Үндэсний аудитын газраас 1687 төлбөрийн акт гаргасан бөгөөд үүний 1273 төлбөрийн акт биелсэн. Харин төрийн аудитын газраас 2871 албан шаардлага гаргасны 2076, 2019 онд 2897 албан шаардлага гаргасны 2376 албан шаардлага нь биелсэн<sup>37</sup> бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх нь төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлах нэг чухал үндэслэл болжээ.

Үүнийг Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын 4 дэх талд “...Төрийн аудитын тухай хуулиар төрийн аудитын байгууллагаас акт тавих, албан шаардлага өгөх харилцааг зохицуулсан хэдий ч уг харилцааг нарийвчлан

<sup>32</sup> Төрийн аудитын тухай хууль, 2003 он.

<sup>33</sup> Мөн тэнд.

<sup>34</sup> Хууль тогтоомжийн тухай хууль, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх хэсэг.

<sup>35</sup> Төрийн мэдээлэл №20 /1122/, (УБ, 2020), 934 дэх тал

<sup>36</sup> Б.Мөнхцэцэг, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, зохистой хариу арга хэмжээ авах нь , (УБ, 2023), 6 дахь тал, Холбоос: <https://audit.mn/wp-content/uploads/2023/11/2.-%D0%90%D1%83%D0%B4%D0%B8%D1%82%D1%8B%D0%BD-%D1%88%D0%B8%D0%B9%D0%B4%D0%B2%D1%8D%D1%80%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3%D0%B6%D0%B8%D0%BB%D1%82%D0%B8%D0%B9%D0%B3-%D2%AF%D0%BD%D1%8D%D0%BB%D1%8D%D1%85-%D0%B7%D0%BE%D1%85%D0%B8%D1%81%D1%82%D0%BE%D0%B9-%D1%85%D0%B0%D1%80%D0%B8%D1%83-%D0%B0%D1%80%D0%B3%D0%B0-%D1%85%D1%8D%D0%BC%D0%B6%D1%8D%D1%8D-%D0%B0%D0%B2%D0%B0%D1%85-%D0%BD%D1%8C.pdf> , Сүүлд үзсэн огноо: 2024.09.18.

<sup>37</sup> Мөн тэнд

зохицуулах, журам батлах, эрх хэмжээ олгох асуудлыг боловсронгуй болгох...”<sup>38</sup> гэж дурдсанаас тодорхой харж болно.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсны дараа Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаарын тушаалын хавсралтаар “албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмыг баталсан.<sup>39</sup> Тус журмыг 2.1-д “албан шаардлага” гэдгийг хууль зүйн хүрээнд “төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж буй аудитын явцад алдаа, зөрчлийг таслан зогсоож, зохих арга хэмжээ авахыг шалгадагч этгээдэд хариуцуулж даалгасан, заавал биелэгдэх шинжтэй захиргааны акт байна” гэж тодорхойлсон.

Мөн уг журмын дагуу албан шаардлага өгөхөд нийтлэг харгалзах 11 үндэслэлийг анхлан бий болгожээ. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;
2. Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй;
3. Өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан;
4. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн;
5. Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн;
6. Төсвийг зориулалт бусаар зарцуулсан;
7. Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
8. Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй;
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;
10. Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;
11. Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал зэрэг болно.

Түүнчлэн, 2023 оны үйл ажиллагааны тайлангаас үзвэл мөн 2,737 төлбөрийн акт, 6,734 албан шаардлага хүргүүлсэн гэжээ.<sup>40</sup>

<sup>38</sup> Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, (УБ, 2023), 4 дэх тал, Холбоос: <https://audit.mn/wp-content/uploads/2020/09/watermarked-9.pdf> , Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

<sup>39</sup> Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230567480661&showType=1> , Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

<sup>40</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ,2024), 30 дахь тал, Холбоос: <https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

## 22 дугаар зүйл. Албан шаардлага, төлбөрийн актыг мэдэгдэх

22.1. Төрийн аудитын байгууллага албан шаардлага, төлбөрийн актыг шалгагдагч этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй аудитад хамрагдагчид Захиргааны ерөнхий хуульд заасан журмаар мэдэгдэнэ.

Төрийн аудитын байгууллагаас гаргаж буй албан шаардлага, төлбөрийн акт нь захиргааны актад хамаардаг бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд заасан захиргааны актын 6 шинжийг агуулдаг гэж үздэг.<sup>41</sup> Энэ ч утгаараа албан шаардлага болон төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуульд заасан журмаар мэдэгдэхээр хуульчилсан.

Захиргааны ерөнхий хуулийн 4.2.6-д бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог хангах зарчмыг тусгасан. ЗЕХ-иар захиргааны байгууллагын гадагш чиглэсэн шийдвэрийн талаар зохицуулж байгаа тул хэрэв ямар нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тухайн гаргах шийдвэрээр хөндөхөөр байвал уг этгээдэд захиргааны холбогдох үйл ажиллагааны талаар заавал урьдчилан мэдэгдэх, тэдний санал авах, сонсох ажиллагааг явуулж, шийдвэр гаргах үүргийг захиргаа хүлээнэ.

Энэ зарчмыг ЗЕХ-ийн 26 дугаар зүйл- оролцогчийг сонсох, 27-28 дугаар зүйл сонсох ажиллагаа явуулах хэлбэр, журам болон сонсох ажиллагаа хийхгүй байх тохиолдол, 43 дугаар зүйл захиргааны актыг мэдэгдэх тайлбарлах заалтуудаар тус тус нарийвчлан зохицуулсан.<sup>42</sup>

Мөн албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмаар албан шаардлага, төлбөрийн актыг мэдэгдэх хүрээнд хэд хэдэн чухал заалтыг нарийвчлан журамласан байна. Үүнд

1. төрийн аудитын байгууллагын албан шаардлага, төлбөрийг актыг шалгагдагч этгээдэд мэдэгдэх бөгөөд баримтаар нотолж, баталгаажуулах<sup>43</sup>
2. Шалгагдагч этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдээс санал, тайлбар ирсэн тохиолдолд аудитор, аудитын менежер судлан, хэрхэн шийдвэрлэх талаар санал бэлтгэж, тэргүүлэх аудитор танилцуулан шийдвэрлүүлэх<sup>44</sup>
3. Албан шаардлага, төлбөрийн актад эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж албажуулан, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болно.<sup>45</sup>
4. Орон нутаг дахь төрийн аудитын байгууллага нэгдсэн удирдамжтай аудитаар албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох бол аудитыг нэгтгэсэн байдлаар хянан удирдаж байгаа албан хаагчдаас санал авч, тэргүүлэх аудитор энэ журмын дагуу хянаж баталгаажуулах<sup>46</sup> гм.

<sup>41</sup> Захиргааны ерөнхий хууль, 2015 он.

<sup>42</sup> Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (УБ, 2017), 62 дахь тал.

<sup>43</sup> Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг.

<sup>44</sup> Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг.

<sup>45</sup> Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг.

## 23 дугаар зүйл. Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах

23.1. Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.

Захиргааны ерөнхий хуулийн 82 дугаар зүйлд “Захиргааны шийдвэр гүйцэтгэл”<sup>47</sup>, 83 дугаар зүйлд “Захиргааны шийдвэр гүйцэтгэлд тавигдах шаардлага”<sup>48</sup>-ыг хуульчилсан. Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангахыг тулд захиргааны ерөнхий хуулийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхээр хуульчилсан ч албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын дөрөвдүгээр бүлгээр албан шаардлага төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавихыг процессыг журамласан.

Тодруулбал, тус журмын дагуу аудитын баг албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг тооцож, баталгаажуулах, хяналт тавихтай холбоотой 3 үүргийг хүлээсэн байна. **Нэгдүгээрт**, аудитор өөрийн гүйцэтгэсэн аудитаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл цуглуулах, Албан шаардлага, төлбөрийн актын бүртгэл, хяналтын хуудсыг бэлтгэж баталгаажуулах, **Хоёрдугаарт**, аудитын менежер албан шаардлага, төлбөрийн актыг нэгтгэн бүртгэж, хэрэгжилтийг тооцож, баталгаажуулах ажлыг тухайн нэгжийн хэмжээнд нэгтгэж, зохион байгуулах, **Гуравдугаарт**, тэргүүлэх аудитор албан шаардлага, төлбөрийн актыг бүртгэх, хэрэгжилтийг тооцож, баталгаажуулах үйл ажиллагааг хянаж, удирдлагаар хангах зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, албан шаардлага, төлбөрийн биелэлтийн хэрэгжилтийг хангах нь төрийн аудитын тухай хуулийн зорилготой шууд уялдахаар байна.

Төлбөрийн актын биелэлтийг авч үзвэл, Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн шалгагдагч этгээдэд 2023 онд 242.2 тэрбум төгрөгийн 2,737 төлбөрийн акт тогтоосноос 35.8 тэрбум төгрөг, өмнөх оны үлдэгдлээс 19.5 тэрбум төгрөгийг барагдуулжээ. Тайлант хугацааны эцэст 286.0 тэрбум төгрөгийн 825 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна. Төрийн аудитын байгууллагаас 2023 онд гүйцэтгэсэн аудитын явцад тогтоосон төлбөрийн актын дүн 2019 оноос 12.5 дахин, өмнөх оноос 50.5 хувиар өссөн байна. Харин хэрэгжилтийн дүн өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа боловч 78.6 хувь нь хэрэгжүүлэх хугацаа болоогүйгээс шалтгаалжээ.<sup>49</sup>

Албан шаардлагын биелэлтийг авч үзвэл, шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй тул алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд 2023 онд 6,328.4 тэрбум төгрөгийн 6,734 албан шаардлага хүргүүлж 2,215.6 тэрбум төгрөгийн 5,276 албан шаардлага, өмнөх онд хэрэгжээгүй 3,601.9 тэрбум төгрөгийн 1,524 албан шаардлагаас 3,063.6 тэрбум төгрөгийн 1,145 албан шаардлага тус тус хэрэгжсэн байна. Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэж буй аудитын явцад алдаа, зөрчлийг таслан зогсоож, зохих арга хэмжээ авах талаар шалгагдагч этгээдэд хариуцуулж даалгасан 4,648.7 тэрбум төгрөгийн 1,833 албан шаардлагыг дараа онд хэрэгжүүлэхээр байна.<sup>50</sup>


<sup>47</sup> Захиргааны ерөнхий хууль, 2015 он.

<sup>48</sup> Мөн тэнд

<sup>49</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ, 2024), 31 дэх тал, Холбоос: <https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.


<sup>50</sup> Мөн тэнд

## Хүснэгт 5. Албан шаардлага /ангилал, тэрбум төгрөг/



Нийт албан шаардлагын 35.0 хувь хэрэгжсэн ба гүйцэтгэл, нийцлийн аудитын хүрээнд өгсөн албан шаардлагын 13.2 хувь, санхүүгийн тайлангийн аудитын 49.5 хувь нь хэрэгжсэн. Нийт хэрэгжээгүй албан шаардлагын 53.2 хувь нь хэрэгжилтийг тооцох хугацаа нь болоогүй.<sup>51</sup>


Зураг. Албан шаардлагын хэрэгжилт



Дээрхээс үзвэл, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох, мэдэгдэх, биелэлтийг хангах эрх зүйн зохицуулалт төрийн аудитын тухай хуулийн зорилгод нийцэж байна. Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох, мэдэгдэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналт үндсэн зорилгод нийцэж байна. Харин албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт, биелэлтийг хангах эрх зүйн хэм хэмжээний хувьд цаашид анхаарах тодорхой асуудал байна.

Тухайлбал, Төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг агуулсан цахим мэдээллийн сан үүсгэж, энэ үйл явцыг цахим системээр хянаж удирдах, удирдлагыг мэдээллээр хангах боломжтой болгох шаардлагатай байна. Энэ ажлыг судалгааны хүрээнд цуглуулж, боловсруулсан мэдээллийг улам баяжуулах, цар хүрээг нь өргөтгөх замаар хэрэгжүүлэх боломжтой юм.

<sup>51</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ, 2024), 31 дэх тал, Холбоос:<https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.



Төрийн аудитын байгууллагын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулах, хариуцагчид хүргүүлэх болон түүний хэрэгжилтийн үйл явц, үр дүнг харуулсан хувийн хэргийг (хянах самбар) шийдвэр тус бүрд нээж хөтлөх үйл явцыг загварчилж, цахим хэлбэрт шилжүүлэхийг санал болгож байна. Энэ үйл явц нь шийдвэр гаргахаас эхлээд биелэлтийг тооцож баримтжуулан үр дүнг нь баталгаажуулж дуусах хүртэл хугацааг хамрах бөгөөд дараагийн тайлант хугацаанд тухайн байгууллагыг хариуцах аудиторт бэлэн мэдээлэл болохоос гадна өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитор юу хийх ёстойг чиглүүлэх боломжтой байх ёстой.

Төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт, албан шаардлагыг ялгаж ангилах, нэгтгэхээс гадна мэдээллийн цахим сан үүсгэхэд шаардлага хангахуйц байдлаар дугаарлах аргачлал, загварыг боловсруулж, баталгаажуулах шаардлагатай.

Аудитын явцад нийтлэг илэрдэг алдаа, зөрчилтэй асуудлыг тухайн асуудалтай зөрчилдөж байгаа болон тухайн асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгох хууль эрх зүйн акттай нь уялдуулсан цахим мэдээллийн сан бий болгож, түүнийг аудиторуудад лавлагаа мэдээлэл байдлаар ашиглуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзэж байна

### **3.2.2. Практикт нийцэж байгаа байдал**

“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд төрийн аудитын тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Энэ шалгуур үзүүлэлтийг ихэвчлэн тухайн хуулийг хэрэгжүүлэгч этгээдээс болон байгууллагаас уг зохицуулалт практикт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг тогтооход түлхүү ашигладаг. Мөн хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа эерэг болон сөрөг ямар үр дагаврууд байгааг тодорхойлох бөгөөд хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал, түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоо практикт байгаа эсэхийг тооцох юм.

#### **20 дугаар зүйл.Төрийн аудитын тайлан**

20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Төрийн аудитын үр нөлөөтэй тогтолцоог бий болгон хөгжүүлж төлөвшүүлэх, хүлээн зөвшөөрөгдсөн аудитын бодлого зорилтууд, чанар, хянан удирдлага, түүний үр нөлөөт байдлыг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд аудитын сэдвийн 2024-2027 оны стратегийг боловсруулан баталж хэрэгжүүлж эхэлснээс гадна аудитын чанарын хяналтын журмыг шинэчлэн мөрдөж байна.

Зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аудитын шийдвэр, зөвлөмжийн мөрөөр хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тодорхой саналуудыг бэлтгэн хүргүүлж, хэлэлцүүлэн УИХ-аас 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Тус хуулиар 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан, хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.”, 37 дугаар

зүйлийн 37.2 хэсэгт ....”аудитын тайлан зөвлөмжийн хэрэгжилтийг....” нэмэлт, өөрчлөлтийг тус тус оруулж баталсан.<sup>52</sup>

Төрийн аудитын тухай хуулийн 20.2-т зааснаар төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө. Энэ зөвлөмжийн дагуу шалгагдагч байгууллага эсхүл холбогдох этгээд зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний төлөвлөгөө бэлтгэн аудитын тайлан хүлээн авснаас 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлдэг.

Өөрөөр хэлбэл зөвлөмж дээрх асуудал бүрийг шалгагдагч байгууллага 30 хоногийн дотор яаралтай засаж, сайжруулах ёстой юм.

### **33 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хуралтай харилцах**

33.5.Монгол Улсын Ерөнхий аудитор нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Улсын Их Хуралд хүргүүлнэ.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн 27 дүгнэлтийг өгсөн. Тухайлбал:

- Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого ба тусламжийн дүн 17,126.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18,159.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.
- Төсвийн орлого давж, алдагдал буурсан хэдий ч төсвийн зарлагын тэлэлт нь засгийн газрын гадаад өрийг нэмэгдүүлсэн;
- Улсын төсвийн орлого төлөвлөснөөс давж, тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал буурсан хэдий ч төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй;
- Орон нутгийн төсвийг 2022 оны хөгжлийн бодлогын зорилтын арга хэмжээтэй уялдуулж төлөвлөөгүй, хөрөнгийг зориулалт бус үр ашиггүй зарцуулсан зөрчлүүд давтагдсан;
- Автозамын түгжрэл бууруулах хүрээнд гэрээ байгуулсан 373 төсөл, арга хэмжээнээс 229 нь бүрэн хэрэгжсэн, 132 нь хэрэгжих шатандаа, 12 нь хэрэгжиж эхлээгүй;
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл байршуулах ажлын зохион байгуулалт хангалтгүйгээс төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод байдал бүрэн хангагдаагүй;
- ЭМДС болон НДС-ийн Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлагын барагдуулалт хангалтгүй байгаагаас тус сангуудын эх үүсвэр дутагдах эрсдэлтэй гэх мэт<sup>53</sup>

Мөн Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын үр дүнг нэгтгэн тайлагнажээ.

<sup>52</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ,2024), 15 дахь тал, Холбоос:<https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

<sup>53</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ,2024), 38 дахь тал, Холбоос:<https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

Аудитын дүнд үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдад 10, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 4, Сангийн сайдад 11, Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргад 2, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 5, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд 1, Аймгийн засаг дарга нарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.<sup>54</sup>

Улсын Их Хуралд толилуулсан асуудал зарим асуудлыг дурдвал;

- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө"-ний зорилго, зорилтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлахдаа тусгасан эсэхэд анхаарах;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталснаар төсвийн захирагчид төрийн өмч, хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах эрх зүйн орчин бүрдсэн боловч хуулийн зарим зүйл, заалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн өөрчлөх зэрэг болно.

### **35 дугаар зүйл. Гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулах**

35.1. Аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудитор энэ тухай прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлнэ. Прокурорын байгууллага Ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар Ерөнхий аудиторт хариу мэдэгдэнэ.

Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас тайлант онд сахилгын шийтгэл ногдуулахаар 355 албан шаардлага өгснөөс 262 буюу 73.8 хувь хэрэгжсэн бөгөөд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн 25 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Тодруулбал, аудит хийх явцад гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул энэ онд прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар 25 асуудлын холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлсэн нь бүгд төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд байжээ.

Өөрөөр хэлбэл, нийт зөрчлийн 0.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бөгөөд үүнийг прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг хамт шилжүүлжээ. Харин прокурорын байгууллага ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар ерөнхий аудиторт ямар хариу өгсөн талаар мэдээлэл байхгүй.

### **37 дугаар зүйл. Төрийн аудитын нээлттэй, ил тод байдлыг хангах**

37.2. Төрийн аудитын байгууллага төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл агуулснаас бусад аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан журмын дагуу улирал бүр гаргаж, өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

Төрийн аудитын чиг үүргийг хэрэгжүүлэгч зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 13, төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 32, нийт 45 удаа хэвлэлийн мониторинг хийж гүйцэтгэсэн. Мэдээллийн ил тод байдал, төрлөөр:

<sup>54</sup> Мөн тэнд



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын 4,106 (60.2%) тайланг нээлттэй аудитын цахим хуудас (open.audit.mn)-д байршуулсан. Мөн төрийн аудитын байгууллагын аудитын тайлангийн талаар 39 сонин, сэтгүүлд, 5,096 мэдээллийг олон нийтийн сүлжээнд (facebook, Twitter) байршуулж, мэдээ мэдээллийн ил тод байдлыг хангажээ.

Түүнчлэн, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, аудитын тайлан, дүгнэлтийн талаар радио, телевиз, сайтын 112 мэдээ, нэвтрүүлэгт орсон бөгөөд хэлэлцүүлэг нэвтрүүлэгт 1 удаа, зочны цаг нэвтрүүлэгт 11 удаа, телевизийн мэдээнд 31 удаа, сайтын видео мэдээнд 14 удаа оролцуулж, 9 телевиз, 10 сайт, өдөр тутмын 3 сонинд ярилцлага өгөх зэргээр мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэсэн талаар тайланд дурдсан.<sup>55</sup>

Мөн төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хараат бус аудиторын дүгнэлтээр “шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 145 мэдээллийн 86.2 хувийг, ҮАГ нийт 171 мэдээллийн 92.4 хувийг тус тус хуульд заасан хугацаанд нь бүрэн байршуулсан” гэж дүгнэжээ.<sup>56</sup>

<sup>55</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ,2024), 70, 71 дэх тал, Холбоос:<https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.

<sup>56</sup> Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ,2024), 121 дэх тал, Холбоос:<https://d.parliament.mn/tusul/22dd1d1a-d47c-410b-b1ee-f99bb12d4025>, Сүүлд үзсэн огноо: 2024.09.19.



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

### 4.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүгнэлт, зөвлөмж

#### Зорилгод хүрсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх үүргийг хуульчлахдаа мэдэгдэл хүлээн авагчийг тодорхой зааж өгөөгүй нь НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилтыг зохих түвшинд хүртэл хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

Ялангуяа НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6 дахь хэсэгт *‘эрх бүхий байгууллага, албан тушаалтанд’* гэж заасан нь яг хэнд хандах нь ойлгомжгүй, төөрөгдөл үүсгэхүйц зохицуулалт юм.

Иймд ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх үүргийг хуульчлахдаа мэдэгдэл хүлээн авагчийг тодорхойгүй, хэт ерөнхий байдлаар томъёолох бус илүү нарийвчлан дэлгэрүүлэх шаардлагатай. Ингэснээр нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хуулиар хүлээсэн албан үүрэг хоорондын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөн төрийн албан хаагчдад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, аливаа хууль бус үйлдлээс өөрийгөө хамгаалах боломж нөхцөл бүрдэнэ.

#### Практик нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд

НАНБХАСЗАСЗУСтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэхээр заасан боловч *‘бусад этгээд’* гэдэгт хэнийг ойлгох талаар нэр томъёоны тодорхойлолт байхгүй байна. Үүнээс шалтгаалан уг зохицуулалт хэнд үйлчлэх нь тодорхойгүй байхын зэрэгцээ мэдээлээгүй тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт заасны дагуу эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан нь хариуцлагаас мултрах, мөн зүйл заалтыг өөрт ашигтайгаар буруу тайлбарлаж хэрэглэх нөхцөлийг бүрдүүлжээ. Мөн уг зохицуулалтаас өөр ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх талаар хуулийн зохицуулалт тодорхой тусгагдаагүй байна.

Судалгаанаас үзвэл иргэдийн ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх байдал өссөн нь энэ төрлийн харилцааг хуульчлан зохицуулах хэрэгцээ шаардлага бий болсныг илтгэж байна. Тодруулбал, 2023 оны “Авлигыг мэдээлэх системийн хэрэгцээ шаардлагыг үнэлэх нь” сэдэвт судалгааны ажлын хүрээнд иргэд, олон нийтийн зүгээс авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар өргөдөл, гомдол, мэдээлэл гарган шийдвэрлүүлж буй тодорхой үе шатанд тулгарч буй асуудлыг тодорхойлох зорилгоор иргэдээс асуумж судалгаа авсныг судалгааны холбогдох хэсэгт оруулсан болно.

Мөн иргэдийн хувьд нь авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотойгоор өргөдөл, гомдол гаргах гэхэд нэр, хаяг, регистрийн дугаар зэргийг шаарддаг нь өөрийн хувийн нууцлалыг алдах вий гэх болгоомжлох, цаашлаад зайлсхийх эрсдэлийг үүсгэж байна. Иймээс хуулийн хэрэгжилтийг хянах механизмыг сайжруулахын тулд Авлигатай тэмцэх газрын хянах чиг үүрэгтэй нэгж, албан хаагчдын тоог нэмэгдүүлэх, мөн мэдээлэгчийг хамгаалах тогтолцоог НАНБХАСЗАСЗУСтХ-д бий болгох шаардлагатай байна.

## **4.2. Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүгнэлт, зөвлөмж**

### **Зорилгод хүрсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох, мэдэгдэх, биелэлтийг хангах эрх зүйн зохицуулалт нь төрийн аудитын тухай хуулийн зорилгод нийцэж байна. Ялангуяа, албан шаардлага, төлбөрийн акт тогтоох, мэдэгдэхтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналт үндсэн зорилгыг нийцэж байна. Харин албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилт, биелэлтийг хангах эрх зүйн хэм хэмжээний хувьд цаашид анхаарах тодорхой асуудал байна.

Тухайлбал, Төрийн аудитын байгууллагаас гаргасан зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг агуулсан цахим мэдээллийн сан үүсгэж, энэ үйл явцыг цахим системээр хянаж удирдах, удирдлагыг мэдээллээр хангах боломжтой болгох шаардлагатай байна. Энэ ажлыг судалгааны хүрээнд цуглуулж, боловсруулсан мэдээллийг улам баяжуулах, цар хүрээг нь өргөтгөх замаар хэрэгжүүлэх боломжтой юм.

Төрийн аудитын байгууллагын зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулах, хариуцагчид хүргүүлэх болон түүний хэрэгжилтийн үйл явц, үр дүнг харуулсан хувийн хэргийг (хянах самбар) шийдвэр тус бүрд нээж хөтлөх үйл явцыг загварчилж, цахим хэлбэрт шилжүүлэхийг санал болгож байна. Энэ үйл явц нь шийдвэр гаргахаас эхлээд биелэлтийг тооцож баримтжуулан үр дүнг нь баталгаажуулж дуусах хүртэл хугацааг хамрах бөгөөд дараагийн тайлант хугацаанд тухайн байгууллагыг хариуцах аудиторт бэлэн мэдээлэл болохоос гадна өмнөх шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитор юу хийх ёстойг чиглүүлэх боломжтой байх ёстой.


Аудитын явцад нийтлэг илэрдэг алдаа, зөрчилтэй асуудлыг тухайн асуудалтай зөрчилдөж байгаа болон тухайн асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгох хууль эрх зүйн акттай нь уялдуулсан цахим мэдээллийн сан бий болгож, түүнийг аудиторуудад лавлагаа мэдээлэл байдлаар ашиглуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй гэж үзэж байна

### **Практик нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийг 2023 оны 07 сарын 07-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулсан. Ийнхүү нэмэлт, өөрчлөлтөөр оруулах болсон шалтгаан нь аудитын тайлан зөвлөмжийн үр дүнг нэмэгдүүлэх зорилготой. Энэхүү шинэ зохицуулалт нь батлагдаад жил гаруйн хугацаа өнгөрч байгаа ч практик тодорхой үр дүнгээ өгч, зөвлөмж дээрх асуудал бүрийг шалгагдагч байгууллага 30 хоногийн дотор яаралтай засаж, сайжруулах боломжийг олгож байна.

Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33 дугаар 33.5 дахь хэсэгт Монгол Улсын Ерөнхий аудитор нь нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитын дүгнэлт хийж Улсын Их Хуралд хүргүүлэхээр заасан. Үндэсний аудитын газрын хувьд энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлж, 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудитын дүгнэлт хийж 27 дүгнэлтийг өгсөн. Энэхүү дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайдад 10, Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 4, Сангийн сайдад 11, Монгол Улсын сайд, нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргад 2, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 5, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд 1, Аймгийн засаг дарга нарт 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасны дагуу 2023 онд Төрийн аудитын байгууллагаас тайлант онд сахилгын шийтгэл ногдуулахаар 355 албан шаардлага өгснөөс 262 буюу 73.8 хувь хэрэгжсэн бөгөөд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл



байдал илэрсэн 25 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Нийт зөрчлийн 0.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн бөгөөд үүнийг прокурорын байгууллагад мэдэгдэж эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг хамт шилжүүлжээ. Харин прокурорын байгууллага ерөнхий аудитораас шилжүүлсэн мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн талаар ерөнхий аудиторт ямар хариу өгсөн талаар мэдээлэл байхгүй. Иймд цаашид төрийн аудитын үйл ажиллагааны тайланд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн үр дүнгээс гадна тухайн шийдвэрийг хэрхэн шийдвэрлэх дүн мэдээг оруулах шаардлагатай.

Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан төрийн аудитын нээлттэй ил тод байдлыг хангах эрх зүйн зохицуулалт нь практик хэрэгжиж байна. Үүнийг Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэл, нийцлийн аудитын 4,106 (60.2%) тайланг нээлттэй аудитын цахим хуудас ([open.audit.mn](http://open.audit.mn))-д байршуулсан болон төрийн аудитын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны тайланд хийсэн хараат бус аудиторын дүгнэлтээр “шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих нийт 145 мэдээллийн 86.2 хувийг, ҮАГ нийт 171 мэдээллийн 92.4 хувийг тус тус хуульд заасан хугацаанд нь бүрэн байршуулсан” гэсэн дүгнэлтээр тодорхойлж болно.



## НОМ ЗҮЙ

### I. Монгол Улсын хууль тогтоомж


1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, (2012 он).
2. Захиргааны ерөнхий хууль, (2015 он.)
3. Хууль тогтоомжийн тухай хууль, (2015 он).
4. Төрийн аудитын тухай хууль, (2020 он).

### II. Хэм хэмжээний акт

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050”
2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”
3. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
4. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”
5. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”

### III. Монгол хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, судалгааны тайлан, эмхэтгэл

1. Авлигатай тэмцэх газар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 100 асуулт, хариулт, (УБ, 2012).
2. Авлигатай тэмцэх газар, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь гарын авлага, (УБ, 2019).
3. Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2019).
4. Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2020).
5. Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2021).
6. Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2022).
7. Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2023).
8. Авлигатай тэмцэх газрын 2024 оны эхний хагас жилийн тайлан, (УБ, 2024).
9. Төрийн албаны зөвлөл, Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн 2023 оны тайлан, (УБ, 2024).
10. Авлигатай тэмцэх газар нар, “Авлигыг мэдээлэх системийн хэрэгцээ шаардлагыг үнэлэх нь” судалгааны тайлан, (УБ, 2024).
11. Б.Мөнхцэцэг, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх, зохистой хариу арга хэмжээ авах нь, (УБ, 2023).
12. Төрийн аудитын байгууллага, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайлан 2023, (УБ, 2024).
13. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, (УБ, 2017).



### **III. Гадаад улсын хууль тогтоомж**

1. Code of Conduct for Members of Parliament, 2005, <https://publications.parliament.uk/pa/cm5803/cmcode/1083/report.html>.
2. Conflict of Interest Act, 2006, <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-36.65/fulltext.html>.
3. Parliamentary Standards Act, 2009, <https://www.legislation.gov.uk/ukpga/2009/13/contents>.
4. Code of Conduct for Members of Parliament, 2005, <https://publications.parliament.uk/pa/cm5803/cmcode/1083/report.html>.

### **V. Монгол цахим эх сурвалж**

1. Эрх зүй мэдээллийн нэгдсэн сан <https://legalinfo.mn/mn>.
2. Авлигатай тэмцэх газрын цахим хуудас <https://iaac.mn>

### **VI. Гадаад цахим эх сурвалж**

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын цахим хуудас <https://www.unodc.org/>.